

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.7-д “Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно.” гэж;

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 77-д “...нийгмийн хор аюул, үйлдэгдэж байгаа арга, хэлбэрээс хамаарч зарим гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах эрүүгийн хариуцлагыг оновчтой болгох зорилгоор Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж тус тус тусгасан.

1.2.Практик шаардлага

-Монгол Улсын хэмжээнд 2022 онд хүнийг алах гэмт хэргийн улмаас 202 хүн хохирч, үүнээс 183 нь нас барж, 21 хүн гэмтсэн байна.

Сүүлийн 4 жилд хүнийг алах гэмт хэргийн халдлагад 782 хүн өртөж, хохирогчдын 92 хувь нь нас барсан байна. Хүнийг алах гэмт хэрэг болон энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдын тоо сүүлийн 3 жил тогтвортой өсөж, хохирогчдын олонх энэ төрлийн гэмт хэргийн улмаас нас барж, эрүүл мэндэд нь хүнд хохирол учирсан байна. Энэ гэмт хэргийн улмаас учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлүүлэх боломжгүй буюу хүний амьд явах эрх зөрчигддөг тул нийгмийн хор аюул ихтэй гэмт хэрэгт тооцогддог бөгөөд энэ ч үүднээс дэлхийн улс бүр эрүүгийн хууль тогтоомждоо хүнийг алах үйлдлийг гэмт хэрэгт тооцож, энэхүү гэмт үйлдэлтэй ялын хатуу чанга бодлогоор тэмцдэг байна.

Сүүлийн жилүүдэд хүнийг алах гэмт хэргийн улмаас хүүхэд, тэр дундаа бага насны хүүхэд хохирох явдал буурахгүй байна. Тухайлбал, 2019 онд 197 гэмт хэрэгт 4 хүүхэд, 2020 онд 192 гэмт хэрэгт 8 хүүхэд, 2021 онд 194 гэмт хэрэгт 2 хүүхэд, 2022 онд 199 гэмт хэрэгт 7 хүүхэд тус тус хохирч, нас барсан байна.

Гэмт этгээдүүд ихэвчлэн бага насны хүүхдийг биеэ хамгаалж чадахгүй, бага насны хүүхэд гэдгийг мэдсээр байж, өөр гэмт хэргийг нуун далдлах зорилгоор гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж амь насыг нь хөнөөсөн байна.

Гэмт этгээдүүдийн дийлэнх нь хохирогчтой гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн байгаа бөгөөд удаан хугацаанд гэр бүлийн хүчирхийлэлд байлган, тарчлаасны эцэст амь насыг хөнөөсөн байна. Мөн гэмт этгээд үйлдсэн гэмт хэргээ нуун далдлах, гэмт хэргийн ул мөрөө баллах зорилгоор хохирогч бага насны хүүхдийг алсан тохиолдол цөөнгүй бүртгэгдсэн байна.

Иймд бага насны хүүхдийг алах гэмт хэрэгт оногдуулах ял хариуцлагыг чангатгах бодлого шаардлагатай байна.

-Хүчиндэх гэмт хэрэг нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалд халдаж, улмаар хүний амьд явах эрх, эрүүл амьдрахын халдашгүй байдалд ихээхэн хохирол, хор уршиг учруулдаг нийгэмд аюултай гэмт хэрэг юм.

2022 онд энэ гэмт хэргийн улмаас 552 хүн хохирч, 59 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеэс хохирсон хүн 94 буюу 20.5 хувиар, гэмтсэн хүн 8 буюу 15.7 хувиар тус тус өссөн байна.

Сүүлийн 4 жилд хүчиндэх гэмт хэргийн гаралт нэмэгдэж, энэ төрлийн гэмт хэргийн улмаас 1975 хүн хохирчээ. Ялангуяа хохирогчдын тоо сүүлийн 3 жилд огцом өсжээ. Үүний дотор энэ төрлийн гэмт хэргийн улмаас хүүхэд, тэр дундаа бага насны хүүхэд хохирох явдал буурахгүй байна. Тухайлбал, 2019 онд 481 гэмт хэрэгт 169, 2020 онд 505 гэмт хэрэгт 248, 2021 онд 439 гэмт хэрэгт 278, 2022 онд 550 гэмт хэрэгт 362 хүүхэд тус тус хохирчээ.

2021-2023 оны эхний хагас жилийн хугацаанд хяналтын шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн нийт хэргийн тоог авч үзэхэд, Улсын дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн нийт 583 хэргийн 11.3 хувь буюу 66 хэрэг нь бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг байна.

Эцэслэн шийдвэрлэгдсэн нийт 68 ял шийтгүүлэгчийг насны байдлаар нь ангилан авч үзвэл:

- 15-18 насныхан 6;
- 19-25 насныхан 14;
- 26-35 насныхан 18;
- 36-45 насныхан 15;
- 46-с дээш насныхан 15 хүн байна.

Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдыг насны хувьд авч үзвэл, 3-6 настай 11, 7-10 настай 11, 11-14 настай 48 хохирогч байна.

Бага насны хүүхдийг хүчиндэж, улмаар жирэмсэн болгосон, бэлгийн замын халдварт өвчин халдаасан, хохирогчийг тохуурхан доромжилж үйлдсэн тохиолдол цөөнгүй хувийг эзэлж байна.

Бага насны хүүхдийг хүчиндсэний улмаас хохирогч жирэмсэлсэн тохиолдолд бүгд (100 хувь) үр хөндүүлсэн байгаа нь хохирогчийн цаашдын эрүүл мэнд, бие бялдар, оюун санааны хөгжилд асар хортой талаар мэргэжлийн эмч нар хэлдэг. Мөн хохирогчийг хүчиндэж, бэлгийн замын халдварт өвчин халдаасан тохиолдолд бага насны хүүхдийн эрүүл мэндэд ихээхэн хохиролтой бөгөөд хохирогч хүчиндүүлсний улмаас сэтгэцийн өвчтэй болсон, амиа хорлосон, амиа хорлохоор завдсан,

хүчиндүүлснээс хойш бусадтай замбараагүй бэлгийн харьцаанд орсон явдал түгээмэл байна.

Ийнхүү бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах шаардлагатай байна.

Түүнчлэн гэмт этгээдүүд ихэвчлэн гэр бүл, төрөл садны хамаарал бүхий харилцаатай болон өмнө нь танилын харилцаатай байх тохиолдол 76.5 хувь буюу дийлэнх хувийг эзэлж байна. Эцэг, эхдээ болон бусдад хэлбэл ална, эрүүл мэндэд нь хохирол учруулна хэмээн заналхийлж, бага насны хүүхдийг хүчиндсэн байх бөгөөд хохирогч айж эмээсний улмаас гэмт этгээдийн үйлдлийг нууж өнгөрдөг нь дахин хүчиндүүлэх, цаашид удаан хугацаанд энэ гэмт хэргийн халдлагад өртөх нөхцөлийг бүрдүүлж байна.

Иймд энэ төрлийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг уртасгаж, тусгайлан зохицуулах шаардлагатай байх бөгөөд ингэснээр хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хүүхдийн эсрэг хүчирхийллийн ноцтой гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, ял завшуулах явдлаас сэргийлэх ач холбогдолтой.

-Сүүлийн жилүүдэд мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах асуудал нэмэгдэж, энэ нь хүний эрх, эрх чөлөөнд халдах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүсэхэд хүргээд байна.

Иймд мөрдөн шалгах ажиллагааны талаар албаны үүргийн дагуу олж мэдсэн алба хаагч, ажилтан прокурорын зөвшөөрөлгүйгээр мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг задруулсан, шүүгч, прокурор, хууль сахиулагч, өмгөөлөгч, мөрдөн шалгах ажиллагааны нууцыг албаны үүргийн дагуу олж мэдсэн алба хаагч, ажилтан мөрдөн шалгах ажиллагааны нууцалсан баримт, мэдээллийг зориуд задруулж, нууцалсан гэрчийг илчилж хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан үйлдэлд оногдуулах ялыг чангаруулах шаардлагатай байна.

-Улсын хэмжээнд 2023 оны эхний 8 сарын байдлаар 15094 зам тээврийн осол, хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 0.6 хувиар өсөж, нийт ослын 12569 буюу 83.2 хувь нийслэлд, 2525 буюу 16.8 хувь нь орон нутагт бүртгэгдэж, зам тээврийн осол хэргийн улмаас 347 хүний амь нас хохирч, 2026 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеэс хүний амь нас хохирсон тохиолдол 5.7 хувиар буурч, гэмтсэн хүн 9.3 хувиар өссөн байна.

Дээрх осол, хэргийн 615 тохиолдол нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсоны улмаас үйлдэгджээ.

Энэ оны эхний 8 сарын байдлаар хүүхэд өртсөн зам тээврийн осол 529 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 9.5 хувиар өссөн, 37 хүүхэд нас барсан нь өнгөрсөн оны мөн үеэс 27.5 хувиар буурсан хэдий ч гэмтсэн хүүхэд 555 бүртгэгдсэн нь 8.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Ослын улмаас нас барсан 37 хүүхдийн 21 буюу 56.7 хувь автомашинд зорчиж явсан, 13 буюу 35.1 хувь нь явганаар хөдөлгөөнд оролцсон, 3 буюу 8.1 хувь жолооч буюу мотоцикл жолоодсон бол явган зорчигч хэлбэрээр бүртгэгдсэн 13 тохиолдлын 5 буюу 38.4 хувь жолооч хөдөлгөөн эхлэх үедээ зам орчны байдлыг биеэр шалгаагүйн улмаас автомашин орчим байсан хүүхдийг дайрч амь насыг нь хохироосон байгаа бол

зам тээврийн осолд өртсөн хүүхдүүдийн 246 буюу 46.5 хувь эмэгтэй, 283 буюу 53.4 хувь эрэгтэй, нийт 529 ослын 26 буюу 4.9 хувь нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон этгээдийн буруутай үйлдлээс шалтгаалжээ.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил, зам тээврийн ослыг сүүлийн 7 жилийн байдлаар авч үзэхэд согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчлөөс шалтгаалж жил бүр дунджаар 110 орчим хүний амь нас хохирсон байна.

Гудамж замын эргүүл, хяналтаар 1,862,819 зөрчлийг илрүүлснээс 1,338,444 буюу 71.8 хувийг нийслэлд, 524,375 буюу 28.2 хувийг орон нутагт бүртгэгдсэн бөгөөд согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 33,726 зөрчлөөс 16,168 буюу 47.9 хувийг нийслэлд, 17,558 буюу 52.1 хувийг орон нутагт тус тус илрүүлсэн байна.

Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, бууруулахаар осол, хэргийн товч мэдээлэл, шалтгаан нөхцөл, хор уршиг, эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулснаар хүний амь нас хохирсон тохиолдол мөн оны өмнөх үеэс 5.7 хувиар буурсан үзүүлэлттэй хэдий ч согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчлийг илрүүлэх арга хэмжээг Улсын хэмжээнд нэгдсэн байдлаар зохион байгуулахад дунджаар 690 гаруй зөрчил бүртгэгдэж байгаа нь цаашид энэ төрлийн зөрчил өсөх хандлагатай байна.

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох үйлдэл нь нийгэм болон эдийн засгийн олон хүчин зүйлээс шалтгаалж байгаа боловч энэ төрлийн зөрчил, гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлага хангалтгүй зэргээс шалтгаалан тоон үзүүлэлт буурахгүй байна.

Иймд согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн этгээд тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн болон согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож хүний эрүүл мэндэд хохирол учруулсан, амь насыг нь хохироосон үйлдэлд хүлээлгэх хариуцлагыг чангатгах зайлшгүй шаардлагатай байна.

-Авлигатай тэмцэх бодлогын хүрээнд Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан авлигын гэмт хэргээр ял шийтгэгдсэн ялтанг хорих ялаас хугацаанаас нь өмнө суллахгүй байх асуудал тулгарч байна.

Дээр дурдсан хэрэгцээ, шаардлагыг үндэслэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөлд дараах асуудлыг тусгана.

-Бүх насаар хорих ял оногдуулахаар зааснаас бусад хүүхдийн эсрэг зарим гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлэх өөрчлөлтийг тусгана.

-Хүнийг алах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд заасан гэмт хэрэг, арван дөрвөн насанд хүрээгүй хүнийг хүчиндэх, энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан, бага насны хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөг, хүүхдийн эсрэг, хоёр, түүнээс олон хүнийг, Монгол Улсын хил нэвтрүүлж, байнга тогтвортой, зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн хүн худалдаалах гэмт хэрэгт өршөөл үзүүлэхгүй байх нэмэлтийг тусгана.

-Хүнийг алах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд заасан гэмт хэрэг, арван дөрвөн насанд хүрээгүй хүнийг хүчиндэх, энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан, бага насны хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөг, хүүхдийн эсрэг, хоёр, түүнээс олон хүнийг, Монгол Улсын хил нэвтрүүлж, байнга тогтвортой, зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн хүн худалдаалах гэмт хэрэг, Хорин хоёрдугаар бүлэгт заасан авлигын гэмт хэргийг үйлдсэн ялтныг хорих ялаас хугацааны өмнө суллаж, хяналт тогтоохгүй байх зохицуулалтыг тусгана.

-Бага насны хүүхдийг алах, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах ялыг чангатгах өөрчлөлтийг тусгана.

-Бага насны хүүхдийн насны хязгаарыг нэмэгдүүлэх зохицуулалтыг тусгана.

-Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлд заасан хүчиндэх гэмт хэргийг үйлдлийн шинжээр нь ялгаж, хүчээр бэлгийн харьцаанд орох, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэлд ялгамжтайгаар ял оногдуулах, хүчээр бэлгийн харьцаанд орох үйлдлийг гэмт хэргийн хүнд ангилалд хамааруулж, оногдуулах ялыг чангатгах өөрчлөлтийг тусгана.

-Мөрдөн шалгах ажиллагааны талаар албаны үүргийн дагуу олж мэдсэн алба хаагч, ажилтан прокурорын зөвшөөрөлгүйгээр мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг задруулсан, шүүгч, прокурор, хууль сахиулагч, өмгөөлөгч, мөрдөн шалгах ажиллагааны нууцыг албаны үүргийн дагуу олж мэдсэн алба хаагч, ажилтан мөрдөн шалгах ажиллагааны нууцалсан баримт, мэдээллийг зориуд задруулж, нууцалсан гэрчийг илчилж хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан үйлдэлд оногдуулах ялыг чангаруулах өөрчлөлтийг тусгана.

-Согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон үйлдэлд оногдуулах ялын бодлогыг чангатгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгмийн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар Эрүүгийн хуулийн холбогдох бүлэг, зүйлд заасан гэмт хэргийн гаралт буурах, бага насны хүүхдийг хүчиндэх болон алах гэмт хэргийн ялын бодлогыг чангатгах, гэмт хэрэгтнийг өршөөлд хамруулахгүй байх, хорих ялаас хугацаанаас өмнө суллахгүй байх зохицуулалтыг тусгаснаар бага насны хүүхдийн эсрэг үйдэгдэж байгаа гэмт хэргийн тоо буурна гэж үзэж байна.

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон тохиолдолд оногдуулах ял хариуцлагыг чангатгаснаар зам тээврийн ослын гаралт буурах, ослын улмаас амь нас, эд хөрөнгө хохирохоос урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэх, холбогдох хууль тогтоомжтой уялдсан байдал, хуулийн төслийг дагалдан гарах хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

---oOo---